



## Бүлэг сэдэв: 4 “ Хүний эрх ба хууль

Сэдэв: Хүний эрхийн талаар төр ямар үүрэг хүлээх вэ?  
Монгол улсын иргэн ямар үүрэгтэй вэ?

Хамрах хүрээ: 9 анги

УЛААНБААТАР  
2021

Багш: З. Цэвэгмиджав

# THE LAW

Монгол улсад одоогийн байдлаар хүчин  
төгөлдөр үйлчилж буй 641 Монгол  
Улсын хууль, 525 Монгол Улсын олон  
улсын гэрээ бүртгэлтэй байна.



Бид өмнөх хичээлээрээ хууль,  
дүрэм журам болоод хүний  
эрхийн хамгаалал, ангилалын  
талаар үзэж судалсан.

Өнөөдрийн хичээлээрээ бүгдээрээ  
хүний эрхийн талаар төр ямар  
үүрэг гүйцэтгэдэг тухай мөн иргэд  
ямар үүрэгтэй вэ? Гэх  
ойлголтуудыг судлана.  
Эхлээд та бүгд өдөр тутамдаа  
төрийн ямар үйлчилгээ авдаг  
талаараа эргэцүүлэн бодно уу?





Аливаа улс төр оршин буй нэг илрэл нь нутаг дэвсгэр, ард иргэдтэй, тэдгээрийг харъяалах засаг захиргаатай байх юм.

Иргэд шууд болон төлөөллийн байгууллагуудаараа төр түүний албан хаагчдыг сонгон улмаар хууль дүрэм боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх үүргийг төрд хариуцуулж өгдөг.





Төр иргэдийн өмнө хүлээсэн үүргээ өөрийн байгууллага, албан хаагчдаараа дамжуулан хэрэгжүүлэхийг **төрийн захиргаа** гэдэг.

Эдгээр төрийн албаны байгууллагууд нь төрийн нэрийн өмнөөс хуулийг хэрэгжүүлэх, түүний биелэлтийг хянан шалгах явцдаа иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хууль ёсны шаардлага гарган захирамжилж байдаг тул **төрийн захиргааны байгууллага** хэмээгддэг.







Төр түүний байгууллагын эрх хэмжээг хуулиар тогтоож хуульчилдаг. Өөрөөр хэлбэл төрийн алба нь тодорхой эрх зүйн үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг тул байгууллага бүрийн эрх хэмжээг Үндсэн хууль болон ходбогдох бусад хуулиар тогтоодог.

Захиргааны алба нь төрийг төлөөлөх эрх, үүрэгтэй бөгөөд хуулийн хэм хэмжээнд нийцүүлэн бусад байгууллага, иргэд **заавал дагаж биелүүлэх** хэм хэмжээний акт батлан гаргах, тодорхой **асуудал шийдвэрлэх эрхтэй** байна. Мөн төрийн нэрийн өмнөөс урамшуулах, шагнах, хууль зүйн хариуцлагыг хүлээлгэх зэргээр тодорхлй үйлдлийг зөвшөөрөх болон хориглох эрхтэй байна.





**ТӨРНЬ ИРГЭДИЙН ЭРХ, ЭРХ  
ЧӨЛӨӨГ ХАНГАЖ,  
ХАМГААЛАХ ҮҮРГИЙГ  
ХҮЛЭЭДЭГ.**

Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулиараа хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, түүнийг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгэм хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг төрд даалгасан байдлаар илэрнэ.





**ТӨРӨӨС ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ  
БУЙ ҮЙЛЧИЛГЭЭГ БҮХ ХҮН  
АМД ХҮРТЭЭМЖТЭЙ,  
ЧАНАРТАЙ, ТАСРАЛТГҮЙ  
ХҮРГЭХИЙН ТУЛД ТӨРИЙН  
ЗАХИРГААНЫ АЛБА  
ТОДОРХОЙ БҮТЭЦ ЗОХИОН  
БАЙГУУЛАЛТТАЙ БАЙДАГ..**

Үндсэн хуулийн дагуу манай улс  
нь төрийн байгууламжийн хувьд  
нэгдмэл бөгөөд нутаг дэвсгэр нь  
зөвхөн засаг захиргааны нэгжид  
хуваагддаг.







## ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖИЙН ХУВЬД

Монгол улс нь аймаг, нийслэл, сум,  
дүүрэг, баг, хороо гэсэн засаг  
захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид  
хуваагддаг тул захиргааны  
тогтолцоо нь дараах дөрвөн  
түвшинтэй байна.





**ЗАСАГ ЗАХИРГААНЫ  
ТОГТОЛЦОО НЬ ДӨРВӨН  
ТҮВШИНТЭЙ БАЙНА.**

1. Төрийн захиргааны төв  
байгууллага.

2. Аймаг нийсэлийн захиргаа

3. Сум дүүргийн захиргаа

4. Баг хорооны захиргаа





**Захиргааны байгууллагын гол үүрэг нь иргэдтэй харилцаж, чиг үүргийнхээ дагуу тэдэнд үйлчлэх явдал юм.** Тухайлбал **нэг цэгийн** үйлчилгээ: төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй, шуурхай хүргэх зорилгоор аймаг дүүргүүдэд байгуулан ажиллуулдаг.

**Нэг цэгийн** үйлчилгээний төвөөс үзүүлдэг зарим үйлчилгээнүүдэд

Хөдөлмөр нийгмийн халамж

Нийгмийн даатгал

Иргэний бүртгэл

Эд хөрөнгийн бүртгэл

Газрын харилцаа

Иргэний өргөдөл, гомдол

Нотариат, банк



Сургууль, эмнэлэг, нутгийн захиргааны байгууллага, шүүх, цагдаа, мэргэжлийн хяналтын алба зэрэг байгууллагууд хүний ямар эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах талаар үйл ажиллагаа явуулдаг болохыг тодорхойлоорой.

Харин иргэдийн хувьд өөрсдийн эрх ашигт хамаарах аливаа асуудлыг шийдүүлэхээр захиргааны байгууллага албан тушаалтантай харилцах шаардлага байнга гардаг.





ЗАХИРГААНЫ  
БАЙГУУЛЛАГЫН НИЙТЛЭГ  
ШИНЖҮҮД:

Хуульд захирагдаж хуулийн дагуу  
үйл ажиллагаа явуулдаг.

Нийтийн ашиг сонирхлыг  
гүйцэлдүүлэхийн төлөө ажилладаг.

Хувь хүн байгууллагын эрх  
ашгийг хөндсөн шийдвэр гаргаж,  
нийтийг засаглах эрхтэй.







Мөн Үндсэн хуульд иргэд төрийн байгууллагад зөрчигдсөн эрхээ сэргээх, хамгаалах зорилгоор өргөдөл гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан байдаг. Үүнийг иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулиар зохицуулна.

Хүний эрх зөрчигдсөн тохиолдолд шүүх, цагдаа, прокурор зэрэг хуулийн байгууллагад хандах шаардлагатай.





Хүний эрх, эрх чөлөө  
зөрчигдөхөөс сэргийлэх,  
зөрчигдсөн тохиолдолд эрхийг нь  
сэргээн эдлүүлэхэд туслалцаа  
үзүүлж ажилладаг байгууллага  
бол “Хүний эрхийн үндэсний  
комисс” юм.

Хүний эрхийн үндэсний комисс нь  
хүний эрхийн талаар иргэдийн  
гаргасан гомдлыг хүлээн авч,  
зөрчлийг шалган шийдвэрлэх үйл  
ажиллагаа явуулдаг.





Хүний эрхийг хамгаалах үндсэн  
чиг үүрэг бүхий байгууллага  
болон шийдвэрлэх асуудлууд:

Цагдаагийн байгууллага	Эд зүйл хулгаалах, дээрэмдэх зэрэг гэмт үйлдлийг таслан зогсоох
Шүүхийн байгууллага	Иргэд хоорондын гэрээний дагуу эд зүйл, өмч хөрөнгийг өмчлөхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх
Захиргааны байгууллага	Захиргааны албан тушаалтан иргэдийн эрхийг зөрчсөн шийдвэр гаргасныг цуцлах
Хүний эрхийн үндэсний комисс	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсэн боловч төрийн байгууллагууд зохих ёсоор хүний эрхийг хамгаалаагүй тохиолдолд эрхийг сэргээн эдлүүлэх





Энэ мэтчилэн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан хууль шийдвэрийг баримтлан иргэдэд үйлчилнэ. **Нөгөө талаас иргэд тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээнэ.**

Эх орон надад юу өгсөн бэ? Гэж асуухын өмнө  
Эх орондоо би юу өгч чадах вэ? Гэж өөрөөсөө асуу  
хэмээн АНУ ерөнхийлөгч асан Ж. Кеннеди

Хүний эрхийн тулгуур зарчим,  
үнэт зүйлсийг төр, иргэн аль аль нь  
баримталж хамгаалан, бэхжүүлэх  
үүрэгтэй.





**Хүний эрхийг хамгаалах гэдэг нь хувь хүний хувьд хүний эрхийн зарчим хэм хэмжээг даган мөрдөж, бусдын эрхийг хүндэтгэх, нийгмийн үйл хэрэгт оролцоотой, хариуцлагатай байхыг хэлнэ.**

Хүн бүрийн хариуцлага, оролцоо нь ардчилсан, шударга нийгмийг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй.

## Ардчилсан улсын иргэний үүрэгт

Үндсэн үүрэг

Хуулийг  
сахиж мөрдөх

Бусдын эрх,  
эрх чөлөөг  
хүндэтгэх

Эх орноо  
хамгаалах, эр  
цэргийн  
албанд явах

Татвар төлөх







Хүмүүс эрхээ хамгаалах гол нөхцөл нь хүний эрх эрх чөлөөг хууль тогтоомжоор хэрхэн хамгаалж өгснийг сайтар мэдэх явдал бөгөөд хүний эрхийн боловсролтой иргэн гэнэ. Энэ нь мөн бусдын эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхэд нөлөөлнө.

Ардчилсан иргэн байх нь эрхээ эдлэхийн хамт үүргээ биелүүлэхээс эхэлнэ.

Ардчилсан улсын иргэний үүрэгт

Журамт үүрэг

Хөдөлмөрлөх

Эрүүл мэндээ хамгаалах

Байгаль орчноо хамгаалах

Үр хүүхдээ өсгөж, хүмүүжүүлэх





**Анхаарал хандуулсанд  
баярлалаа.**

Эрх зүйн мэдээллийн  
нэгдсэн систем буюу  
[www.Legalinfo.mn](http://www.Legalinfo.mn)  
гэсэн цахим хуудаснаас  
манай улсад мөрдөгдөж  
буй хууль эрх зүйн  
актуудын талаар бүрэн  
мэдээллийг авч болно.

